



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/465

Булган сум

Дадлага, сургууль зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор баталсан "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн хэмжээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 16:00 цагт зохион байгуулсугай.

2. Дадлага сургуульд оролцох төрийн захиргааны болон аж ахуйн, нэгж байгууллагыг нэгдүгээр, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дадлага сургуульд идэвхтэй оролцохыг иргэд, төрийн байгууллага, аж ахуй нэгж байгууллагын дарга, захирал, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


4. Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийн бэлтгэл хангуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, сургуулийг зохион байгуулж, дүнг 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдөр танилцуулахыг Онцгой байдлын газар /хурандаа Ш.Баасандорж/-т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Э.АРИУН-ЭРДЭНЭ

6323010450

Аймгийн Засаг даргын 2023 оны
06 дугаар сарын 06 ны өдрийн
У/А/Б дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт



ДАДЛАГА, СУРГУУЛЬД ОРОЛЦОХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар
2. Шүүхийн Тамгын газар
3. Прокурорын газар
4. Булган аймаг дахь Тагнуулын хэлтэс
5. Цагдаагийн газар
6. Эрүүл мэндийн газар
7. Нэгдсэн эмнэлэг
8. Хүнс, хөдөө аж ахуйн газар
9. “Эрдэнэ-Булган” ЦТСТӨХК-ийн Булган аймаг дахь салбар
10. Боловсрол, шинжлэх ухааны газар
11. Татварын хэлтэс
12. Мал эмнэлгийн газар
13. “Булган Мээж” ОНӨХК
14. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
15. Ус, цаг уур, орчны шинжилгээний газар
16. Нийгмийн даатгалын хэлтэс
17. “Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХК
18. “Монголын цахилгаа холбоо” ХК
19. Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газар
20. Шүүх шинжилгээний алба
21. Төв номын сан
22. Авто тээврийн үндэсний төвийн Булган аймаг дахь салбар
23. Байгаль орчин, аялал жуулчлалын газар
24. Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
25. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
26. Ерөнхий боловсролын сургуулиуд
27. Хөгжимт жүжгийн театр
28. Соёлын ордон
29. Шатахуун түгээх станцууд
30. Худалдаа үйлчилгээний газар
31. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүд
32. Хаан, Хас, Төрийн банк
33. Сумдын Засаг даргын Тамгын газар
34. Сумдын төрийн байгууллаг, аж ахуй нэгж байгууллагууд



**ГАМШГИЙН АЮУЛЫН ТУХАЙ ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГООР АЖИЛЛАХ
ДАДЛАГА, СУРГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго: Монгол улсын "Гамшгаас хамгаалах тухай хууль", 2011 оны Засгийн газрын 339 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", 2011 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам", Засгийн газрын 2017 оны "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай" 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд оршино.

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах нэгж, байгууллага
Нэг. Бэлтгэл ажлын хүрээнд				
1	"Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай" аймгийн Засаг даргын захирамж боловсруулан батлуулах.	05 дугаар сарын 31-нд	ОБГ	Аймгийн ЗДТГ
2	2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 16:00 цагт улсын хэмжээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах сургууль, дадлага зохион байгуулах тухай албан бичгийг сум, орон нутаг, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэх.	06 дугаар сарын 08-ны өдөр	Аймгийн ЗДТГ	ОБГ
3	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дамжуулах холбоо мэдээллийн техник хэрэгслийн дэлгэрэнгүй судалгааг гаргах.	06 дугаар сарын 01-03-ны өдөр	ОБГ	Мэдээлэл, харилцаа холбооны алба
5	Аймгийн хэмжээнд ашиглаж байгаа зарлан мэдээллийн дуут дохиоллын тоног	06 дугаар сарын 02-04-ний өдөр	ОБГ	Сумдын Засаг дарга нар

	төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг шалгаж, дүнг танилцуулах.				
6	Гамшгаас хамгаалах албад, аж ахуйн нэгж, байгууллагын зарлан мэдээлэл дамжуулах журам, хүч хэрэгслийг тодотгох, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгах, зөрчил дутагдлыг арилгуулах, дадлага, сургуулийн бэлтгэл ажлыг хангах, дүнг танилцуулах.	06 дугаар сарын 02-05-ны өдөр	ОБГ	Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги бүхий аж ахуйн нэгж, байгууллага	
7	Сумын хэмжээнд зарлан мэдээлэх дуут дохиоллын төхөөрөмжийн дууны тархалт хүрэхгүй байгаа газар орон дээр дуут дохиолол бүхий тээврийн хэрэгслүүдийг байршуулах газруудыг судалж, шийдвэрлэх.	06 дугаар сарын 05-ны дотор	ОБГ	Сумдын Засаг дарга	
8	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх, нүүлгэн шилжүүлэх дадлага, сургууль зохион байгуулах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, сурталчлах.	06 дугаар сарын 01-08-ны өдөр	ОБГ	Аймаг, сумын ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн мэргэжилтэн, Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага	
9	Гамшгаас хамгаалах албад, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах, нүүлгэн шилжүүлэх дадлага, сургууль зохион байгуулах талаар сургалт явуулах, заавар зөвлөмж өгөх.	06 дугаар сарын 02-05-ны өдөр	ОБГ	Гамшгаас хамгаалах албад, аж ахуйн нэгж, байгууллага	
10	Сум, орон нутгийн хэмжээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах, нүүлгэн шилжүүлэх дадлага, сургууль, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх зохион байгуулах захирамж, ажлын төлөвлөгөө гарган бэлтгэл ажлыг хангах.	06 дугаар сарын 01-05-ны өдөр	Сумдын Засаг дарга нар	Аж ахуйн нэгж, байгууллагууд	
11	Зарлан мэдээллийн дохио дамжуулах дадлага, сургууль, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, хамтран	06 дугаар сарын 01-06-ны өдөр	ОБГ	Аймаг, сумын ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн мэргэжилтэн, Сумдын Засаг дарга	

	ажиллах тухай албан бичгийг хэвлэл, мэдээллийн байгууллагад хүргүүлэх.				
12	Байгууллага бүр гамшгаас хамгаалах төлөвлөгөөндөө тодотгол хийж, өөрийн байгууллагын ойролцоо “Цугларах талбай”-г тодотгож, тэмдэгжүүлсэн байх	06 дугаар сарын 01-06-ны өдөр	ОБГ	Сумдын Засаг дарга, Аж ахуй нэгж байгууллагын дарга, эрхлэгч	
13	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулийн үед “Цугларах талбай” дээр ажиллах хэв журам сахиулах, бүртгэл хийх болон бусад шаардлагатай албан тушаалтанг томилгоожуулах	06 дугаар сарын 01-06-ны өдөр	Сумын Засаг дарга нар	Цагдаагийн газар, ОБГ, Багийн дарга нар	
Хоёр. Зохион байгуулах ажлын хүрээнд					
1	Засгийн газрын 2017 оны “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай” 67 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангаж, ард иргэдэд сурталчлан таниулах	06 дугаар сарын 07-ны өдөр	Сумын Засаг дарга нар, ОБГ	Аж ахуй нэгж байгууллагын дарга, эрхлэгч	
2	Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах, нүүлгэн шилжүүлэх дадлага, сургуулийг зохион байгуулах.	06 дугаар сарын 08-ны өдөр	ОБГ	Гамшгаас хамгаалах албад, сум, аж ахуйн нэгж, байгууллага	
3	Цахим мэдээллийн самбараар зарлан мэдээллийн дохио дамжуулах дадлага, сургуулийн талаар олон нийтэд сурталчлах.	06 дугаар сарын 08-ны өдөр	ОБГ	Сурталчилгааны алба	
4	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 16:00 цагт дуут дохио болон мэдээллийн бүх хэрэгслээр дамжуулах.	06 дугаар сарын 08-ны өдөр	ОБГ	Мэдээлэл, харилцаа холбооны алба	
5	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, албадын үйл ажиллагаанд хяналт тавих, заавар зөвлөмж өгөх.	06 дугаар сарын 08-ны өдөр	ОБГ	Сумдын Засаг дарга, Аж ахуй нэгж байгууллагын дарга, эрхлэгч	

6	Орон нутгийн телевиз, радиог ашиглан гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах дадлага, сургуулийн арга хэмжээг ард иргэдэд мэдээлэх.	05 дугаар сарын 31-нээс 06-08-ны өдөр	Сурталчилгааны алба	Сумдын Засаг дарга, Аж ахуй нэгж байгууллагын дарга, эрхлэгч
7	Төрийн захиргааны болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажилчид, иргэдийг аюулгүйн бүсэд шилжүүлэн байршуулах.	06 дугаар сарын 08-ны өдөр	ОБГ	Аж ахуйн нэгж, байгууллагууд
Гурав. Дүгнэх ажлын хүрээнд				
1	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах дадлага, сургууль зохион байгуулсан тухай дүнг Онцгой байдлын газарт ирүүлэх.	06 дугаар сарын 08-ны дотор	Сумдын Засаг дарга	Гамшгаас хамгаалах албад, аж ахуйн нэгж, байгууллага
2	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах дадлага, сургууль зохион байгуулсан тухай тайланг нэгтгэж Онцгой байдлын ерөнхий газар, аймгийн Засаг даргад танилцуулах.	06 дугаар сарын 09-ны өдөр		ОБГ